



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/312

Булган сум

“Хангинахын шугуйн шагайн тойром” эвент үйл ажиллагааг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.9, 13.1.10, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний спорт, аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор “Хангинахын шугуйн шагайн тойром”-ын соёл, спортын эвент үйл ажиллагааг 2025 оны 05 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. “Хангинахын шугуйн шагайн тойром” эвент үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, шаардагдах хөрөнгийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. “Хангинахын шугуйн шагайн тойром”-ын эвент үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг ажлын хэсгийн дарга (Д.Наранбаяр)-д үүрэг болгосугай.

4. Дээрх арга хэмжээнд шаардагдах 14,999,500 (арван дөрвөн сая есөн зуун ерэн есөн мянга таван зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
05 дугаар сарын 13-ны/ний өдрийн
А/312 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

“ХАНГИНАХЫН ШУГУЙН ТОЙРОМ 2025”
ЭВЕНТ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга: Д.Наранбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
Г.Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс,
орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн
хэлтсийн дарга)
Т.Хонгорзул (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны
дарга)
П.Оюунцэцэг (Эрүүл мэндийн газрын дарга)
Б.Эрдэнэбилэг (Цагдаагийн газрын дарга, Хурандаа)
Н.Хишигдорж (Онцгой байдлын газрын дарга, дэд
хурандаа)
А.Гантөмөр (Байгаль орчны газрын дарга)
П.Итгэлбаяр (Хутаг-Өндөр сумын Засаг даргын орлогч)
А.Ганбагана (Сэлэнгэ сумын Засаг дарга)
Д.Эрдэнэбат (Зэд-хантай-бүтээлийн нурууны дархан
цаазат газрын хамгаалалтын захиргааны дарга)
Г.Ариунболд (Аймгийн үндэсний Шагайн холбооны
тэргүүн)

Нарийн бичгийн дарга: Г.Алдармөнх (Соёл, урлаг, аялал жуулчлал,
залуучуудын газрын дарга)

Аймгийн Засаг даргын 2025 оны
05 дугаар сарын 13-ны/ний өдрийн
А/312 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

**“ХАНГИНАХЫН ШУГУЙН ТОЙРОМ 2025”
ЭВЕНТ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
ШАГНАЛЫН ЗАРДАЛ**

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5	6
1	Медаль	ш	27	15,000	405,000
2	Өргөмжлөл	A3 хэмжээтэй /ш/	3	35,500	106,500
		A4-хэмжээтэй /ш/	8	26,000	208,000
3	Хулдаасан хэвлэл	3x5 хэмжээтэй /1ш/	1м2	20,000	300,000
4	Уяа бэхэлгээ	м	20м	1,500	30,000
	Хэсгийн дүн				1,049,500
Багийн харваа мөнгөн шагнал					
1	1-р байр	хүн	-	5,000,000	5,000,000
2	2-р байр	хүн	-	3,000,000	3,000,000
3	3-р байр	хүн	-	2,000,000	2,000,000
4	4-р байр	хүн	-	1,000,000	1,000,000
5	5-р байр	хүн	-	500,000	500,000
6	6-р байр	хүн	-	500,000	500,000
7	7-р байр	хүн	-	500,000	500,000
8	8-р байр	хүн	-	500,000	500,000
Цуваа харваа					
9	1-р байр	хүн	1	500,000	500,000
10	2-р байр	хүн	1	300,000	300,000
11	3-р байр	хүн	1	150,000	150,000
	Хэсгийн дүн				13,950,000
	Нийт дүн				14,999,500